



**GARID - MEBEL**  
SINCE 2009

**ХЭРЭГЛЭГЧИЙН  
ГАРЫН АВЛАГА**



# Гэрээ байгуулахдаа АНХААРАХ ЗҮЙЛС

Үйлчлүүлэгч та гэрээний нөхцөл бүртэй сайтар танилцсаны үндсэн дээр гарын үсгээ зурж баталгаажуулаарай



**1.** Гэрээ байгуулсны дараа тавилгын материал татагдаж үйлдвэрт орж эхэлдэг тул та гэрээ хийхээсээ өмнө тавилгын хийц, загвар, өнгөө сайтар тохирч эцсийн байдлаар шийдвэрээ гаргаарай.



**2.** Цахилгаан бараа болон тавилгандаа суурилах тоноглолуудын хэмжээг бүрэн зөв өгсөн байх шаардлагатай

Гэрээ хийсний дараа үйлдвэрт орохоос өмнө загвар хийц өнгөө өөрчлүүлэх бол яах вэ?



**3.** З а й л ш г ү й шаардлагаар солиулах хэрэгтэй болсон тохиолдолд үнийн дүнгийн 1,5% тай тэнцэх төлбөрийг төлж өөрчлөлт оруулах боломжтой болдог.



# Угсаргаа хийлгэхэд АНХААРАХ ЗҮЙЛС


Манай байгууллага нь зөвхөн тавилга угсралтын ажлыг гүйцэтгэх бөгөөд засвар, сантехник болон цахилгааны ажлыг та мэргэжлийн хүмүүст хандаж хийлгэхийг зөвлөж байна.



**1.** Угсаргаа хийлгэхээс өмнө таны байр ашиглалтанд орсон шал, хана, тааз, плита зэрэг заслын болон цахилгаан, сантехникийн ажил бүрэн хийгдэж дууссан байх шаардлагатай.



**2.** Зарим материал болон тоноглол тасарсан тохиолдолд хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэх бөгөөд хамтран тохиролцсоны үндсэн дээр асуудлыг шийдвэрлэнэ.



**3.** Бүтээгдэхүүний их багаас хамаарч **1-3** хоногийн дотор угсралт суурилуулалтын ажил хийгдэнэ.




**4.** Тавилгын гүйцэтгэл бүрэн дууссан гэж үзвэл бүтээгдэхүүн хүлээлцэх акт-д гарын үсэг зурна. Чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн хийгдсэн тохиолдолд солих буюу засварласны дараа гарын үсэг зурж болно.





**1.** Тавилга хийгдэж байх явцад таны гэрийн хана, тааз, шалны далий муруй байдлаас шалтгаалж засвар орсноор угсралтын үйл явц удаашрах магадлалтай.



**2.** Зарим тохиолдолд тавилгын онцлогоос хамааран бүтээгдэхүүн угсрагдсаны дараа чулууны хэмжээг дахин нягтлан авч зүсвэрт оруулах шаардлагатай болдог тул угсралтын үйл явц удаашрах магадлалтай.



**3.** Бусад үйлдвэрлэгчээс шалтгаалсан буюу шил толь, бадуушиг зэрэг алдаатай, гэмтэлтэй үйлдвэрлэгдсэн тохиолдолд дахин үйлдвэрлэлд оруулснаар тавилгын гүйцэтгэлийн хугацаа хойшлогдох магадлалтай.



**4.** Импортоор оруулж ирдэг барааны хомсдол, тасалдалтаас үүдэн хүлээлт үүсэх магадлалтай.




**5.** Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол тухайн нөхцөл байдал үргэлжилсэн хугацаагаар хойшлогдоно.

Угсралтын үйл явц

ЯМАР ҮЕД  
УДААШРАХ  
МАГАДЛАЛТАЙ  
ВЭ?





[www.garidmebel.mn](http://www.garidmebel.mn)

Утас: 7000-8897

Facebook : Garid mebel LLC

e-mail : [Since2009@garidmebel.mn](mailto:Since2009@garidmebel.mn)

Хаяг : ХУД, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Avto-Land-н баруун талд Design Central-н 3 давхар